



- хуучин мэдүүлэг;
- шинэ мэдүүлэг;
- татвар төлсөн баримт;
- нягтлан бодогчоос авсан илүү төлөлтийг баталгаажуулсан тооцоо нийлсэн баримт.

Албан хүсэлт бичихдээ илүү төлсөн татварыг

буцаан авах талаар тодорхой дурдаж, шилжүүлэг хийх банкны нэр, данс эзэмшигчийн овог нэр, дансны дугаар, буцаан авах татварын дүнг зөв тусгасан байна.

2.4.Татвар буцаан олгох

ГЕГ-ын татварын орлогын газар таны хүсэлтийг үндэслэн Сангийн яамны Төрийн сангийн газарт албан хүсэлт гаргана. ГЕГ-ын албан хүсэлтийг үндэслэн Төрийн сангаас таны дансанд шилжүүлгээр татварыг буцаан олгох болно.

Танд лавлах зүйл байна уу!



1800-1281

Гааль сонсож байна



Талархал



Гомдол



Асуулг



Санал

ГААЛИЙН ЛАВЛАХ УТАС

Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар үйлчлүүлэгч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүсэлт, гомдол, мэдээллийг хүлээн авах, гаалийн хууль тогтоомж, заавар, журам, гаалийн үйлчилгээний талаар мэдээ, мэдээллээр хангах, сан бүрдүүлэх зорилгоор “Гаалийн лавлах-1281” нээлттэй утас ажиллуулж байна.

Гаалийн байгууллагын үйл ажиллагааны талаархи иргэд, байгууллагын асуултуудыг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган мэдээлэл, гомдол саналын мөрөөр шаардлагатай арга хэмжээ авах, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээлэл, зөвлөлгөө өгөх, сурталчилгаа хийх болон гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.



МОНГОЛ УЛСЫН
ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ТАТВАР БУЦААН ОЛГОХ ТУХАЙ ЗӨВЛӨМЖ



Хаяг:
Сүхбаатар дүүрэг, "Их тойруу-81/1",
Улаанбаатар-14193, Монгол Улс
Утас: (976-11) - 350049
Факс: (976-11) - 350048
E-mail: info@customs.mn
Интернет: <http://www.customs.gov.mn>

УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

ТАТВАР БУЦААН ОЛГОХ ТУХАЙ ЗӨВЛӨМЖ



Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд заасны дагуу гаалийн байгууллага илүү төлөгдсөн гаалийн болон бусад татварыг дараах тохиолдолд буцаан олгоно:

-бараа ердийн тарифаас нэн тааламжтай тарифт, эсхүл нэн тааламжтай тарифаас хөнгөлөлттэй тарифт шилжсэн;

-энэ хуулийн 8.6-д заасны дагуу гаалийн байгууллагын тодорхойлсон үнээс татгалзсан;

-гаалийн болон бусад татварыг илүү төлсөн, эсхүл илүү ногдуулсан бусад тохиолдолд.

Буцаан олгох гаалийн болон бусад татварт гаалийн байгууллага хүү төлөхгүй.

Мэдүүлэгч хүсвэл илүү төлөгдсөн татварыг дараагийн ачилтаар ирэх барааны татварт шилжүүлэн тооцож болно.

Илүү төлсөн татварыг суутган тооцох, татвар буцаан олгох талаар зааварчилгаа:

1.Татвар суутган тооцох тохиолдолд: Анх бүрдүүлэлт хийсэн гаалийн газар, хороо үүнийг шийдвэрлэнэ. Үүнд дараах алхамтай хийгдэнэ.

1.1.Шинэчилсэн бүрдүүлэлт хийх

Өмнө нь гаалийн бүрдүүлэлт хийсэн гаалийн газар, хорооны бичиг баримтын байцаагч дээр очиж эхний гаалийн мэдүүлгийг засварт буцааж, гаалийн мэдүүлгийг шинэчлэх. Үр дүн нь хуучин мэдүүлэг дээр байсан татвар төлөх дүн багасч гарсан байна.

1.2. Илүү төлөлтийг баталгаажуулах

Бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан ГУБ-аас тухайн гаалийн газар, хорооны татвар хариуцсан нягтлан бодогч ГУБ дээр очиж татвар илүү төлснийг



баталгаажуулж програмаас тооцоо нийлсэн баримт хэвлэн авна.

1.3.Албан хүсэлт гаргах

Тухайн гаалийн газар, хороонд албан хүсэлт гаргана.Хүсэлтэд дараах бичиг баримтыг хавсаргана. Үүнд:

-хуучин мэдүүлэг;

-шинэ мэдүүлэг;

-татвар төлсөн баримт;

-нягтлан бодогчоос авсан илүү төлөлтийг баталгаажуулсан тооцоо нийлсэн баримт.

Хүсэлт бичихдээ илүү төлсөн татварыг дараагийн ачилтаар ирэх барааны татварт суутган тооцуулах хүсэлтэй байгаа талаар тодорхой тусгасан байх.

1.4.Харъяа гаалийн газар, хорооны дарга татвар суутган тооцох талаар шийдвэрлэнэ.

2.Татвар буцаан олгох тохиолдолд: Гаалийн ерөнхий газрын Татварын орлогын газар шийдвэрлэнэ.

2.1. Шинэчилсэн бүрдүүлэлт хийх

Өмнө нь гаалийн бүрдүүлэлт хийсэн гаалийн газар, хорооны бичиг баримтын байцаагч дээр очиж эхний гаалийн мэдүүлгийг засварт буцааж, гаалийн мэдүүлгийг шинэчлэх бүрдүүлэлт хийх. Үр дүн нь хуучин мэдүүлэг дээр байсан татвар төлөх дүнг багасаж гарсан байх болно.

2.2. Илүү төлөлтийг баталгаажуулах

Бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан ГУБ-аас тухайн гаалийн газар, хорооны татвар хариуцсан нягтлан бодогч ГУБ дээр очиж татвар илүү төлснийг баталгаажуулж програмаас тооцоо нийлсэн баримт хэвлэн авна.

2.3. Албан хүсэлтийг Гаалийн ерөнхий газрын Татварын орлогын газарт гаргана.

Хүсэлтэд дараах бичиг баримтыг хавсаргана. Үүнд: